

Г.БАЗАРВААНЬ- ДХИС-ИЙН УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, СТРАТЕГИЙН ПРОФЕССОРЫН БАГИЙН
ПРОФЕССОР, ДОКТОР,(Ph.D) ЦАГДАГИЙН ДЭД ХУРАНДАА

ТУСГААР ТОГТНОЛЫН ҮНЭ ЦЭНЭ

/ Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний
108 жилийн ойд зориулсан нийтлэл/

Тусгаар тогтнол гэдэг тухайн улс үндэстэн оршин тогтнохын үндэс юм. Мэдээж тусгаар тогтнол гэдэг бол улс гүрний бүрэн эрхийн баталгаа байдаг. Тэгэхээр улс гэж юу вэ? гэдгээс эхлэн тусгаар тогтнолын тухай ярих ёстой болов уу.

Улс үүсэх үндсэн дөрвөн онол байдаг. Үүнд:

1. Хувьслын онол (Evolutionary Theory) Улс нь нөлөө бүхий эртний овог (Family)-ийн үйл ажиллагааны өрнөлийн үр дүнд үүсэхийг хэлнэ. Монгол Улс бол хувьслын онолоор үүссэн улс. Өөрөөр хэлбэл, эртний Богд эзэн Чингисийн дээд өвөг Бөртэ чоно, Гуа маралаас үүтгэлтэй алтан ургийн эхэс дээдсийн үйл хэргийн үр дүнд Их Монгол улсыг байгуулсан юм.
2. Хүчирхийллийн онол (The Force Theory) аливаа улс ил далд хүчэрхийллийн үр дүнд үүсдэг гэж үздэг онолын сургаал. Хамгийн тод жишээ бол АНУ. Тэд уугуул иргэд болох Индианчуудын газар нутгийг эзлэн өөрийн улсаа байгуулсан байдаг.
3. Тэнгэрийн бошиг (The Divine Right Theory) Улс бурхан тэнгэрийн хүч удирдах явдлаас үүдэлтэй гэж үздэг. Үүний жишээ бол эртний Ром. Ромын хаад өөрсдийгөө тэнгэрийн хүү, өөрөөр хэлбэл, Зевс бурханы үр сад гэж үздэг байв.
4. Нийгмийн гэрээний онол (The Social Contract Theory) Улс нь чөлөөт ард иргэд гэрээ, зөвшилцлийн үр дүнд бий болдог. Сонгодог жишээ нь Швейцарийн холбооны улс. Дөрвөн өөр үндэстэн өөр хоорондоо эрх тэгш харилцахаа илэрхийлэн нэгэн улс болох явдал юм.

Гэхдээ улс байхын тулд дараах атрибут салшгүй шинж чанарыг агуулдаг байна. Эдгээр нь Нутаг дэвсгэр, Хүн ам, Бүрэн эрхт байдал, Төр/Удирдлага болно. Тусгаар тогтнол бол энэ бүх шинж чанарыг агуулсан улс үндэстэн, бүрэн эрхтэй, аль нэг улсын хараат бус, бие дааж оршихыг хэлж буй хэрэг болно.

Монгол Улс тусгаар тогтнолын төлөө үе үеийн эрхэлхэг хөвгүүд амь биеэ үл хайрлан тэмцэж байсан түүхтэй. Бид 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Манж чин улсаас тусгаар тогтнолоо зарласан явдал ч учиртай. Хэрэв зээ бид энэ өдөр тусгаар тогтнолоо зарлаагүй бол өнөөдөр бид тусгаар орших байсан эсэх эргэлзээтэй. Учир нь 1912 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Дундад Иргэн улс тусгаар тогтнолоо зарлаж, Манж чин улсыг залгамжлагч улс болохоо тунхаглах гэж байгааг тухайн үеийн манай тагнуулын байгууллага тогтоож тэднээс өрсөж тусгаар тогтнолоо зарласан юм. Ингэснээр бид ДИУ болон БНХАУ-аас ямагт өмнө нь тусгаар тогтнолоо зарлаж байсан түүхтэй. Иймд бид жил бүрийн 12 дугаар сарын 29-ний өдрийг тусгаар тогтнолын өдөр гэж үеийн үед хүндэтгэн тэмдэглэж явах учиртай юм.

1946 онд олон улсын эрх зүйгээр бүрэн хүлээн зөвшөөрсөн Nation state буюу Үндэсний төрт улс болтлоо биднийг манай хоёр хөрш цөөнгүй худалдаж, цөөнгүй удаа нөлөөний бүсдээ хамруулан гэрээ хийж байсныг бид мэднэ. Энд хоёр хөршөө муулах гэсэн зүйл огт байхгүй.

Зөвхөн эх гүрнүүдийн дунд орших хувь заяа ямар эмзэг, ямар амаргүй байдгийг л тодруулж буй юм. Тухайлбал, 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр БНМАУ Хятадын төлөөлөгчийг бие засахаар гарах хооронд НҮБ-ын гишүүн болох санал хураалт болж, Монгол Улс тус байгууллагын гишүүн болсон тухай үлгэр домгийн шинжтэй яриа байдаг. Энэ бол тийм биш. Хэрэв Хятадын төлөөлөгч Монгол Улсыг НҮБ-ын гишүүн болохын эсрэг санал өгөх байсан бол өмдөндөө шээгээд ч болов эсрэг санал өгөх байсан шүү дээ. Энэ бол БНХАУ Монгол Улсыг НҮБ-ын гишүүн болоход манай талд санал өгч, хүлээн зөвшөөрөөгүй шүү гэх “мессеж”-ийг үеийн үед үлдээсэн хэрэг юм.

Нэгэнтээ Монгол Улсын Ерөнхий сайд асан Анандын Амар “Монгол Улс ямар улс байх нь хамаагүй гагцхүү тусгаар улс байх ёстой” хэмээн тусгаар оршихын утга учрыг цөөн үгээр тодорхойлсон бол эдүгээ бид маршал Х.Чойбалсангийн захиж үлдээсэн “Эрхэмлэж яваарай хэмээн машинд итгэн эрх чөлөө, тусгаар тогтнолыг та нарт үлдээв” хэмээх захиасыг ямагт санаж, олон эх орончдын амины үнээр бүтсэн эрх чөлөө, тусгаар тогтнолоо ямагт хадгалан явах ариун үүргийг Монгол Улсын иргэн бүр хүлээж яваа юм шүү гэдгийг онцлон хэлье.

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Үндэсний аюулгүй байдлын тухай ярихын өмнө аюулгүй байдал гэж чухам юу болохыг тайларлах нь зөв. Шинжлэх ухааны аливаа мэдлэг, мэдээлэл тайлбар толиос эхтэй байдаг. Манай нэрт хэл шинжээч Я.Цэвэл гуайн толинд аюул гэдгийг гамшиг зовлон учруулж болох хор хөнөөлтэй юм, харин аюулгүй байдал гэдгийг аюул заналгүй байх, айх эмээх зүйлгүй байх хэмээн тайлбарласан байдаг.

“Аюулгүй байдал” гэдэг нэр томъёо болон түүний агуулгын тухай өнөөг хүртэл нийтээр хүлээн зөвшөөрсөн ойлголт, онолын суурь тогтоогүй. Учир нь аюулгүй байдал гэх ухагдахууны хамрах хүрээ улам бүр өргөжөөд байна. Тухайлбал, өмнө дан ганц цэрэг дайны аюулыг аюулгүй байдлын үндсэн асуудал хэмээн үздэг байсан бол эдүгээ кибер аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, эдийн засгийн хүний гээд аюулгүй байдлын цар хүрээ улам бүр бүр тэлж байна.

Үндэсний аюулгүй байдал гэх нэр томъёоны тухайд XVII зуунаас эхтэй. Европ тивийг 30 жилийн турш сүйтгэсэн дайн 1648 онд дуусч энхийн гэрээг талууд одоггийн ХБНГУ-ын Норд Рэйн Вестфален муж улсын Мюнстер, Оснабрюк хотын орчим байгуулсан байдаг. Гэрээнд хэд хэдэн асуудал туссаны дотор улс орны улс орны үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нэгэн хүчин зүйл болох дотоод хэрэгт оролцохгүй байх зарчмыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөх тухай анх удаа хэлэлцэн тогтжээ. Вестфалийн гэрээ хэмээн түүхэнд үлдсэн энэхүү зарчим улс орныг хүлээн зөвшөөрөх олон улсын эрх зүйг бүрэлдүүлэх үндэс болсон юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал хэмээх манай аюулгүй байдлын тулгуур баримт бичиг байдаг. Энэхүү баримт бичгийн 1.1.1-т “... Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ ...” хэмээн заасан байдаг байдаг. Тэгэхээр манай аюулгүй байдал бол үндэсний язгуур эрх ашгаа хамгаалах явдал байх нь. Тэгвэл Үндэсний язгуур ашиг сонирхол гэж чухам юу болох тухай асуулт үүнээс ургаж гарч байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2-т “... Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана ...” хэмээн заасан байдаг. Өөрөөр хэлбэл, монголын ард түмэн, соёл иргэншил, тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал үүний дотор байгал, экологийн гээд 1.564.116 км² газар нутагт орших монголын гэх бүхий л зүйл бидний язгуур ашиг сонирхол нандигнан хайрлах юмс байдаг байна.

Эх орны минь хөрсөнд байх ширхэг чулуу ч амгалан байх явдал бол бидний язгуур ашиг сонирхол байх нь. Энэ ч тийм. Хүн бол нэг амь гэхдээ энэ амийг амьд аятай байлгах үүднээс агаар, газар дэлхий, өвс ургамал, гол мөрөн, ан амьтан оршдог. Тэд зөвхөн хүн гэх биднийг амьд байлгах үүднээс оршдог. Бүгд амьтай зүйл. Энэ дурдсан бүх зүйл хилийн шугамаар хязгаарладаг нэгэн газарт багтдаг. Үүнийг бид эх орон гэж гэж нэрлэдэг. Эх орны дотор энэ олон амь иргэн таныг амьд байлгахын үүднээс оршдог тул эх орон өөрөө амины үнэтэй байдаг юм. Тиймээс өмнө нь дурдсан тангараг эх орны өмнө тулаад ирэхээрээ амины үнэтэй хариуцлага болдог юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “баталгаатай хангагдсан байдал” гэх тодотгол хэдэнтээ дурдагддаг. Энэ бол заавал, ямагт хангаж байхыг хэлж байгаа нь ойлгомжтой. Иймээс субъектив үнэлгээ бус харин төрийн шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих бүх шатанд объектив үнэлгээ байх ёстой. Өөрөөр хэлбэл бодит үнэлгээ байх ёстой. Учир нь субъектив үнэлгээ нэг талаас аюул, заналыг дутуу эсхүл хэт үнэлж, түүнд хандах төр, нийгмийн хандлага, авах арга хэмжээг бодит бус байлгах эрсдэлтэй байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай, түүний үндэс болсон оршин тогтнолын тухай ярихад маш олон эсрэгцсэн хандлагууд ажиглагддаг. Зарим нь “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд гаднаас хэн ч заналхийлээгүй байна” гэсэн одоогийн байдалд хийсэн дүгнэлт, “эдийн засгийн нийтлэг сонирхол давамгайлж, даяаршиж байгаа нөхцөлд цэргийн хүчээр асуудлыг шийднэ гэдэг хэтэрхий хоцрогдсон зүйл” хэмээн хэт өнгөц төсөөлдөг, гэтэл зарим нь “хятадууд монголчуудыг эдийн засгийн хувьд боомилж, үндэстний хувьд уусгах гэж байна” гэх мэт хэт сэжиглэдэг. Ийнхүү үл ойшоох, хэт дөвийлгөх хоёрын хоорондох асар уудам орон зайд оршин тогтнолын маань бодит асуудал уусч бүдэгрээд байгаа юм. Энэ бүх дүгнэлт хандлага өмнө дурдсан субъектив үнэлгээтэй ихээхэн холбоотой байдаг.

Оршин тогтнолынхоо асуудлыг бүрэн шийдчихсэн улс одоогоор энэ ертөнцөд алга. АНУ их гүрэн хэмээгдэвч тэлэх тусам аюулгүй байдалтай нь холбоотой асуудал энэ дэлхий дээр байхгүй мэт болоод хамаг хүч нөөцөө дэлхий даяар цацаж, эцэст нь эдийн засаг нь тамирдаж эхлээд байна. Орос, Хятад аль аль нь дотор, гаднаа бэрхшээлтэй, тэр бэрхшээл нь даамжирвал оршин тогтнол нь дээсэн дөрөөн дээр дэнжигнэж болзошгүй аюултай байна.

Харин одоохондоо Монгол Улс хөрш хоёр гүрэн маань тогтвортой байгаагийн ачаар гаднаас халдах дайсангүй харьцангуй амар жимир байна. Өөрөөр хэлбэл, Орос, Хятад хоёр улс бүрэн бүтэн, хүчирхэг байгаа, хоорондоо бас найрсаг харилцаатай байгаа учраас манай гадаад аюулгүй байдал өнөөдөртөө баталгаатай байна.

Гэвч ийм байдал хэр удаан үргэлжлэх вэ гэдгийг бид зайлшгүй бодож, тооцож байх ёстой. Хөрш хоёр орон, зэргэлдээ бүс нутагт алсдаа манай аюулгүй байдал, аюулгүй байдлаа хангах бодлогод шууд нөлөө үзүүлж болзошгүй чамгүй олон хүчин зүйл бий. Өнөөдрөөрөө ирээдүйг яг ийм байна гэж таамаглах хэтэрхий гэнэн хэрэг.

Олон улсын байдал, манай хөршүүд, хүрээлэн буй бүс нутгийн байдал сүүлийн хорин жил огт өөр болсон, дараагийн хорин жилд бүр ч өөр болох нь тодорхой.

Тиймээс л бид угтаж харж, алсыг бараалан, оршин тогтнолын аюулгүй байдлаа бэхжүүлэхийн төлөө өнөөдрөөс ажиллах хэрэгтэй юм. Иймд объектив үнэлгээ байхын тулд шинжлэх ухааны онол, арга зүйд суурилсан байх шаардлагатай байдаг.

Орчин үед улс орнууд аюулгүй байдлаа шууд хангах буюу Реалист, хууль, эрх зүйн байримт бичгээр буюу Конституционал байдлаар хангаж байна.

Монгол Улс ч мөн ийм байдлаар хангаж байна. Манай улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй. Өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчин гэж юу вэ? Өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчин гэдэг бол өөр улс руу халдахгүй, харин гаднаас халдвал хамгаалан тэмцэж, бусад улсад энхийг дэмжих ажиллагаа явуулахад бие бүрэлдэхүүнээ илгээнэ гэсэн үг юм.

Манай улс НҮБ-ын мандаттай Энхийг дэмжих цөөнгүй ажиллагаанд оролцож Монгол цэргийн нэр хүнд дэлхийд түгэж эдүгээ бид оролцогч бус харин хандивлагч улс болж, манай цэргийг олон энхийг дэмжих ажиллагаанд урьж оролцуулж байна. Тэгэхээр бид реалист байдлаар буюу батлан хамгаалах, цэрэг-улс төрийн аргаар улсынхаа аюулгүй байдлыг хангаж байна.

Бидэнд аюулгүй байдалтай холбоотой Монгол Улсын хуулиуд, бодлогын томоохон баримт бичиг бий. Үүнд:

1. Үндсэн хууль /1992/,
2. Үндсэний Аюулгүй байдлын үзэл баримтлал /1994, 2010/,
3. Гадаад бодлогын үзэл баримтлал /1994, 2011/,
4. Батлан хамгаалахын Цагаан ном /2001/,
5. Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс /1998/,
6. Батлан хамгаалах бодлогын үндэс /2015/,
7. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль /2018/,
8. Үндэсний аюулгүй байдал болон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийг багтааж ойлгох хэрэгтэй болно.

Түүнчлэн манай улс нэгдсэн олон улсын гэрээ конвенциудыг дурдаж болно. Олон улсын гэрээнд нэгдэж орвол уг гэрээ хэлэлцээрийг дагах зарчим дэлхий нийтэд үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, дотоодын хууль тогтоомжид өөрөөр заасан бол олон улсын гэрээ хэлэлцээрийг баримтлах зарчим үйлчилдэг. Үүнтэй холбоотой манай зарим улс төрч, иргэн өөрийн улсын эрх ашгийг хөндсөн гэрээ хэлэлцээрт нэгдэж ордог гэх ойлголтыг төрүүлэх зүйл ярьдаг. Тэр тийм биш. Монгол Улсын үндсэн хуульд ч бий. Монгол Улсын язгуур эрх ашгийг хөндсөн гэрээ хэлэлцээр, Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичигт нэгдэхгүй, дагаж мөрдөхгүй гэх зарчим баталгаатай хангагдсан байдгийг энд мөн дурдая.

Эцэст нь аюулгүй байдал гэх ойлголтыг маш энгийнээр тайлбарлавал аюулгүй буюу амгалан байна гэдэг товчдоо Зөрчилгүй байхыг хэлж байгаа юм.

Иргэн, улс аль нь ч хоорондоо эвтэй, айх эмээх зүйл байхгүй буюу зөрчилгүй бол аюулгүй байна. Өнөөдөр Монгол Улс хөрш хоёр улстай улс төр, хил, газар нутгийн хурцадмал ямарч маргаангүй, өөрөөр хэлбэл зөрчилгүй тул аюулгүй байна. Харин зөрчилгүй байдлаа ямагт хангаж явах бол аюулгүй байдлыг хамгаалах төрийн тусгайлсан чиг үүргийн байгууллагын алба хаагч төдийгүй иргэн Таны үүрэг болно.